



## ХӨТӨЛИЙН “ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар ХТМ - 01/2020

Улаанбаатар хот

### КОМПАНИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦЭХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 62.1.16 дахь заалтууд болон “Цемент Шохой” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйл 5.6.8 дах хэсгийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. 2020 онд Компанийн үйл ажиллагааны болон үр ашгийн үзүүлэлтийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.
3. Энэхүү шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ХӨТӨЛ ХК,  
ТҮҮНИЙГ ТӨЛӨӨЛЖ ГАНЗОРИГ





## ХӨТӨЛИЙН “ЦЕМЕНТ ШОХОЙ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар ХХМ-02/2020

Улаанбаатар хот

### КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.16 дахь заалтууд болон “Цемент шохой” ХК-ийн дүрмийн 5.6.6 дах хэсгийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.
2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлд Хувьцаа эзэмшигчийг төлөөлөх ердийн гишүүнд дараах нэр бүхий албан тушаалтнуудыг томилсугай. Үүнд:
  1. С.Уранчимэг
  2. Ч.Туул
  3. Б.Мөнхсоёл
  4. Б.Тулга
  5. Б.Батбилэг
  6. Т.Болорчимэг
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг хараат бус 3 гишүүнтэй байхаар зохион байгуулж, дараах нэр бүхий албан тушаалтнуудыг хараат бус гишүүнээр томилсугай. Үүнд:
  1. Б.Цолмонбаатар
  2. Ц.Энхцэнгэл
  3. Т.Мөнхзул
4. Энэхүү шийдвэрийг биелэлтийг хангаж ажиллахыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ ХӨТӨЛ ХК,  
ТҮҮНИЙГ ТӨЛӨӨЛЖ



Г.ГАНЗОРИГ